



**МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ШУУДАН,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2012 оны 11 сарын 26 өдөр

Дугаар 63

Улаанбаатар хот

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа
холбооны газрын даргын зөвлөлийн
бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай


Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн
8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын даргын
2012 оны “Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын даргын
зөвлөлийг байгуулах, даргын зөвлөлийн хурлын дэгийг батлах тухай” 22 дугаар
тушаалын нэг дэх заалтын зөвлөлийн гишүүнд “Бүх нийтийн үйлчилгээний үүргийн
сангийн ажлын албаны дарга” гэж нэмсүгэй.

Хоёр. Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж буй асуудлаар шийдвэр гаргахад
идэвхитэй оролцож, түүний биелэлтэнд хяналт тавин ажиллахыг Даргын
зөвлөлийн гишүүн Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн ажлын албаны
даргад даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.ЖАДАМБАА



113517